



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн  
сургалтад хамруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.15 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаал, Хөдөлмөрийн дотоод журмын 16.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/26 дугаар тушаал, Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны дүрэмийн 2.1.2 дахь заалт, ЦССҮТ-ийн Ёс зүйн салбар хорооны хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдвээр багц цагийн богино хугацааны сургалтад төвийн нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийг холбогдох журмын дагуу хамруулах ажлыг зохион байгуулахыг Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга /Б.Солонго/-д, ажилтнуудын сургалтад хамрагдалтад хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн салбар хороо /Н.Халиун/-нд тус тус даалгасугай.
2. Сургалтад шаардагдах 432.000 /дөрвөн зуун гучин хоёр мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтад идэвхи, санаачлагатай хамрагдахыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд уриалсугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн алба /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР